

# A380

Аэробус А380 онгоц нь дээд доод гэсэн хоёр давхартай.

Дээд давхарт нь 1-р ангиллын болон бизнес ангиллын зорчигчид суудаг. 1-р ангиллын зорчигчдод зориулсан суудлууд эхний хоёр эгнээнд байрлах ба эгнээ бүрт А-D үсгүүдээр тэмдэглэгдсэн дөрвөн сандал байна. 1-р ангиллын суудлуудын хувьд эгнээний 1-р болон 2-р сандлын завсраар мөн 3-р болон 4-р сандлын завсраар үйлчлэгч явна.

3-20-р эгнээнүүд нь бизнес ангиллын зорчигчдын суудлуудаас тогтоно. Эгнээ бүрт зургаан сандал байх ба тэдгээр нь А-F үсгүүдээр тэмдэглэгдсэн байдаг. Эгнээний 2-р болон 3-р сандлын завсраар мөн 4-р болон 5-р сандлын завсраар үйлчлэгч явна.

Доод давхарт энгийн ангиллын зорчигчид суудаг. Эгнээнүүдийг 21-65 тоонуудаар дугаарласан байх ба эгнээ бүрт А-K үсгүүдээр (I үсэг нь нэгийн тоотой адил харагддаг тул ашиглагдахгүй) тэмдэглэгдсэн 10 суудал байна. Эгнээний 3-р болон 4-р суудлын завсраар мөн 7-р болон 8-р суудлын завсраар үйлчлэгч явна.

Суудлын тухай мэдээлэл өгөгдсөн бол түүнийг цонхны хажууд, үйлчлэгчид ойрхон эсвэл аль нь ч биш болохыг тодорхойл.

## Input

Ганц мөрөнд эгнээний дугаар, эгнээн дэх суудлын байрлалыг заасан нэг үсгээс тогтох суудлын мэдээлэл өгөгдөнө

## Output

Хэрэв суудал нь цонхны хажууд бол "window", үйлчлэгчид ойрхон бол "aisle", аль нь ч биш бол "neither" гэсэн үгийг хэвлэнэ

## Example

**Input:**

3C

**Output:**

aisle

**Input:**

64A

**Output:**

window

**Input:**

21F

**Output:**

neither